

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР, БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ СТЕПАН МЕСИЧ НАРЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч Степан Месич Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын урилгаар Монгол Улсад 2008 оны 8 дугаар сарын 2-ноос 5-ны өдрүүдэд төрийн айлчлал хийв.

Хоёр улсын Төрийн тэргүүн (цаашид-Талууд гэж нэрлэх) нар нөхөрсөг уур амьсгалд хоёр талын харилцааны болон харилцан сонирхсон асуудлаар санал солилцлоо.

Айлчлалын үеэр хийсэн яриа хэлэлцээн нь хоёр орны харилцааны бүхий л асуудлыг хамарч, өргөн агуулгатай болсныг Талууд сэтгэл ханамжтай тэмдэглээд, тэдгээрийн үр дүн нь хоёр талын хамтын ажиллагаанд шинэ түлхэц өгөх болно гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлэв.

Талууд улс төрийн яриа, хэлэлцээг үргэлжлүүлэн хөгжүүлэх, эдийн засаг, худалдааны харилцааг эрчимжүүлэх нь хоёр улс, ард түмнүүдийн язгуур эрх ашигт нийцэж байгааг тэмдэглэв.

Талууд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 15 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 2008 оны 5 дугаар сард “Дэлхийн соёлын өвд багтсан Хорват Улсын түүх, соёлын дурсгалт газрууд” нэртэй гэрэл зургийн үзэсгэлэн Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсныг сайшаав.

Талууд хоёр ард түмний хооронд соёл, боловсрол, хүмүүнлэгийн харилцааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэхийн хамт соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаанд ач холбогдол өгч байгааг цохон тэмдэглэв.

Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч С.Месичийн Монгол Улсад хийсэн анхны төрийн айлчлалын үеэр Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Бүгд Найрамдах Хорват Улсын Шинжлэх ухаан, боловсрол, спортын яамны хооронд “Дээд боловсролын салбарт хамтран ажиллах тухай” санамж бичиг, Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, Бүгд Найрамдах Хорват Улсын Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн хооронд хамтын ажиллагааны санамж бичиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хооронд хамтран ажиллах тухай санамж бичиг зэрэгт гарын үсэг зурав.

Олон улсын тавцанд хамтын ажиллагаа гүнзгийрүүлэхийн чухлыг Талууд онцлон тэмдэглэв.

Талууд Нэгдсэн Үндэстний байгууллагыг аюулгүй байдал, тогтвортой байдлыг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн гишүүдийн эрх тэгш харилцааг ханган хэрэгжүүлэх гол хэрэгсэл хэмээн үзэж, олон улсын үйл хэрэгт түүний гүйцэтгэх үүргийг бэхжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлэв.

Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч С.Месичийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлал нь хоёр орны хоорондын найрамдлыг бэхжүүлэх, бүх талын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд чиглэсэн чухал үйл явдал болсныг Талууд тэмдэглэв.

Монгол Улсад элэгсэг дотноор хүлээн авч айчлуулсанд Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч С.Месич Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт талархал илэрхийлж, Бүгд Найрамдах Хорват Улсад албан ёсоор айлчлахыг урив.

2008 оны 8 дугаар сарын 4